

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-9

***1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий
хяналтын сонсголын тов тогтоох тухай/*** 4-8

***2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын
хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай/*** 8-9

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
12 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, С.Лүндэг, З.Мэндсайхан, У.Отгонбаяр;
Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Р.Сэддорж, А.Ундраа;
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Бейсен тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн хариулж, тайлбар хийв.

Б.Бейсен: “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	3
Бүгд:	14

78.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Золжаргал, Б.Найдалаа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 14 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 14 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 92.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 19 минут үргэлжилж, 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
18 цаг 25 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Батчимэг гишүүн, Ганхүлэг гишүүн, Мөнхбат гишүүн, Наранбаатар гишүүн, Бейсен гишүүн, Замира гишүүн, Мөнхбат гишүүн, Наранбаатар орсон байна тээ? Болчихлоо болсон уу? Эхэлж байх уу тээ?

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгосон тойрог, нэрээр танилцуулъя. Сая танилцуулчихлаа шүү дээ бараг. Үргэлжилж хуралдаж байгаа юм чинь одоо цаг аваад яах вэ. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг, Байнгын хорооны тогтоолын төсөл “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох тухай”

Хоёр дахь асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” ийм хоёр асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

Байхгүй. Хэлэлцэх асуудалд оръё.

Байнгын хорооны 24 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар утааны асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол явуулах асуудлыг хэлэлцэн дэмжсэн байгаа. Мөн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1-д сонсгол явуулах талаар гаргасан иргэдийн хүсэлтийг дэмжсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор холбогдох Байнгын хороо сонсголыг товлон зарлана гэж заасны дагуу өнөөдөр сонсголын товыг зарласан тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Өчигдөр ажлын хэсэг хуралдсан байгаа. Тогтоолын төслийн талаар ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн танилцуулна уу.

Чинбүрэн гишүүн танилцуулна уу микрофон нээж өгөөрэй.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ оройн мэнд хүргэе.

Утааны асуудлаар хяналтын сонсгол явуулах талаар цахим системд байршуулсан нийтийн өргөдөл холбогдох хуульд заасан тоонд хүрсэн тул Монгол Улсын Их Хурал авч хэлэлцсэн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Байгаль

орчин, хүнс, хөдөө аж ахуйн хорооны хуралдаанаар утааны асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол явуулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Мөн хуралдаанаар Ерөнхий хяналтын сонсголын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах ажлын хэсгийг 19 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсгийн ахлагч бөгөөд сонсгол даргалагчаар миний бие сонгогдсон.

Ажлын хэсэг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж сонсгол явуулах сэдэв, тов тогтоох асуудлыг хэлэлцсэн бөгөөд асуудлын цар хүрээ, ажиллах боломжийг харгалзан, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан журмыг тус тус баримтлан Ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдөр агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл гэсэн сэдвээр зохион байгуулахаар ажлын хэсгийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Бейсен: Чинбүрэн гишүүнд баярлалаа.

Тогтоолын төслийн талаар асуулт, саналтай гишүүн байна уу? Нэр өгнө үү.

Наранбаатар гишүүнээр тасалъя. Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Энэ Ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдөр зохион байгуулна гэсэн байна. Тэгээд энэ хугацааны хувьд яагаад 2 дугаар сард тавьж байгаа юм бэ? Одоо энэ цаг үед чинь нөгөө утаа чинь арилчих юм биш үү? Бид нарын гол зорилго чинь одоо энэ эрчимтэй яригдаад байгаа үед л энэ асуудлыг тодорхой болгох, сайжруулах, ажиллаж байгаа улсуудад нь үүрэг, чиглэл өгөх нээлттэй болох л ийм үүрэгтэй юм биш үү гэж асууя.

Б.Бейсен: Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Мөнхбат гишүүний яг одоо санаа зовж байгаа асуудлаар манай ажлын хэсгийн гишүүд ч бол бид бас өчигдөр нэлээн дэлгэрэнгүй ярилцсан. Ер нь бол яг одоо бэлтгэл хугацаа нь яг техникийнхээ хугацаа нь бол 1 сарын 23-наас нааш бид зохион байгуулах боломж байхгүй. Тухайлах юм бол ард иргэдээс санал асуулга, дээрээс нь сонсголд оролцох иргэд, төрийн бус байгууллага, байгууллагуудын оролцох нэрсийг авах, сэтгүүлчдийг оруулах энэ тэр гээд зохион байгуулалтын хугацаа нь өөрөө угаасаа 1 сарын 23-наас наана амжих боломж байхгүй.

Хоёрт, бид бас их наашлуулж байгаа нь ердөө сарын дотор л хийх гэж байгаа юм. Сарын дотор. Өнөөдөр чинь бараг ингээд он дуусаж, энэ долоо хоног он дуусаад ирэх жил гээд л бараг гарчихлаа. Энэ хугацаанд бид бас бодитой нэлээн нотолгоотой бас юм ярих хэрэгтэй байна. Тэр утгаараа манай ажлын гишүүдээс бас гаргаж байгаа санал бол дэд сонсголууд, дэд хэлэлцүүлгүүд хийе. Ер нь бид 4 чиглэлээр асуудлыг хөндөж ярина. Энэ нэгд эрүүл мэндэд нөлөөлж байгаа утааны хор нөлөө.

Нөгөөдөх нь энэ олон төсөв мөнгө, санхүүжилт зарцуулаад ямар үр дүн, ямар хугацаанд хэн хэн ямар шийдвэр гаргав гэдгийг ярилцах, мөн технологийн шийдлүүд, шийдэл гэсэн ийм 4 сэдвээр үндсэндээ ярих ийм саналыг манай ажлын хэсгийн гишүүд гаргаж байгаа. Тэр бид бас дэд хэлэлцүүлгүүд хийнэ.

Нөгөө талаасаа магадгүй бид бас зарим зүйл дээр шинжээч нэмж томилох хүртэл ажил гарч магадгүй байна. Яагаад гэвэл их олон арван их наяд төгрөг яригдана. Түүний зарцуулалтуудыг цуглуулах, бид бас сонсголыг мэднэ. Тэгээд төрийн байгууллагууд руу баахан бичиг явуулна. Өөдөөс гөлөг төөрүүлж байгаа юм шиг хачин хачин бичиг явуулдаг. Тэгээд л дахиад л буцаагаад явуулна.

Тийм учраас бид аль болох л энэ богино хугацаанд илүү нотолгоотой, баримттай ярихыг хичээж л байгаа байдал нь энэ. Тийм учраас бид нарын, манай ажлын хэсгийн гишүүдийн олонхын дэмжлэг бол ердөө л, ямар ч байсан 2 сарын хамгийн эхэнд л хийх ийм үүрэг даалгавартай л ажлаа хугацааг тавьсан шүү гэдгийг та бүхэнд дуулгая. Дээр нь олон улсын бас шинжээчийн баг оруулж бас тэр судалгаа хийлгэх гээд байгаа юм утаанаас гарч байгаа.

Жишээлбэл, манай гишүүд хэлээд байгаа. Яг яндангаас нь гарч байгаа утааг судалъя, шинжилье гээд. Би бас өнөөдөр хүртэл бүүр Солонгосын тийм биеэ даасан ТББ судалгаа хийдэг лабораторитой хүртэл холбогдлоо. Бас нэлээн л хугацаа орох юм шиг байна. Тэгэхдээ хэдүүлээ ямар ч байсан амжуулахыг хичээж байгаа.

Б.Бейсен: Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Товын хувьд тэгвэл наана нь маш их ажил байгаа учраас, үүнээс наашлуулах боломжгүй юм байна гэж ойлголоо. Харин хэлэлцүүлгүүдийг бас нэлээн өргөн хүрээтэй, олон талыг хамруулсан байдлаар сайн зохион байгуулах хэрэгтэй байх.

Нэг асуулт нь зөвхөн Улаанбаатар хотын агаарын бохирдол ярих юм уу, аль эсвэл энэ аймгууд чинь бол ер нь дутахааргүй агаарын бохирдолтой, утаатай болсон. Зарим нэг сумд бол ялангуяа бол уул уурхайтай Цогтцэций сум гэх мэтчилэн агаарын бохирдол, тоосжилт, утааны асуудал гээд бас тулгамдсан асуудлууд байгаа.

Тийм учраас та бүхэн энэ сонсголоо ямар хүрээнд явуулах юм? Орон нутгийг оролцуулах юм уу, үгүй юм уу гэсэн ийм асуулт байна.

Б.Бейсен: Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Наранбаатар гишүүн яг чухал зүйл. Ялангуяа ер нь энэ эмч хүний хувьд миний өөрийн судалгаа ч байна, ер нь энэ бид энэ түүхий нүүрстэй холбоотой асар их дэгдэмтгий утаа, хий, хорт хий үүсэж байна. Бүр тэр диметил сульфат гэж яриад байгаа хий бол бүр дэлхийн I-дүгээр дайнд хорт хийгээр ашиглах гэж байсан судалгаанд орж байсан бодис шүү дээ. Тийм утгаар бид одоо Монгол Улс даяараа түүхий нүүрс түлээд л ашиглаж байгаа байхгүй юу. Тийм учраас манай ажлын хэсэг дээр бас энэ асуудал яригдсан. Тэгэхлээр Монгол Улсын хэмжээнд бид ярина.

Тэгэхлээр бид бас нэг бид нарын нэг том асуудал бол яагаад ганцхан одоо Улаанбаатар хотыг та бүхэн яриад байгаа юм. Энэ чинь Үндсэн хуулиараа амьд явах эрхтэй, эрүүл орчинд бид ард иргэдээ хамгаалах үүрэгтэй төр өөрөө. Тэр ч утгаараа бас энэ асуудал бол заавал хөндөгдөнө, энэ асуулт тавигдана. Тэгэхлээр Улаанбаатар л гэж яриад байгаа болохоос одоо хүртэл Улаанбаатараас гараад бид хажуухандаа Налайх руу гарахад л энэ түүхий нүүрсний утаа ямар аймаар байна тийм үү.

Тийм учраас бид энэ асуудлаа нэлээн тийм өргөн хүрээтэй шийдэл дотор бол ер нь, уул нь бол одоо ингээд шийдэл технологи нь зөв байх юм бол тэрийгээ Улаанбаатар, Улаанбаатараас бүх аймгууд ингээд л цаашаа цэцэглээд явж байх ёстой л тогтолцоо шүү дээ. Тэр асуулт бол зайлшгүй гарна л гэж бодож байгаа.

Б.Бейсен: Энэ утааны асуудлаар бид энэ сонсгол хийхдээ бас сахилгын энэ талаар бас ярихгүй бол энэ сахилга бат алдагдсан. Яагаад гэвэл түүхий нүүрс их хэмжээгээр оруулсан. Нөгөө талаараа сайжруулсан түлшний технологийн горим алдагдсан гэж ярьж байгаа. Нөгөө талаар хатаалт дээр нь бас нойтон түлш нийлүүлсэн гээд байгаа. Энэ бүгдийг шалгаад тэгээд гишүүд нийтдээ 20 хэд болов уу? 19 тэгээд 21 болоод орж байгаа энэ. Одоохондоо 11-хэн гишүүн байна гээд байна. Тэгэхээр чинь энд юунд бүгдээрээ жигд оролцоод, зарим бичиг баримтыг нь авах хугацаа алдахгүйгээр, хариу хүлээхгүйгээр газар дээр нь очоод үзчих хэрэгтэй. Гишүүний бүрэн эрхийн хувьд бас ингээд үзэхгүй бол улсын хэмжээний асуудал болж байгаа учраас энэ дээр анхаарч ажиллая.

Шинжилгээний асуудал дээр гадаадын компаниар хийлгэе гээд бас ярьж байгаа. Гол нь одоо ард иргэдийн энэ утааны хоруу чанарын асуудал байгаа. Ард иргэдийн эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн асуудал нэг тогтоох асуудал байгаа. Тийм учраас энэ дээр нэг анхаарч ажиллаарай гэдгийг захъя.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Тэгэхдээ уншиж танилцуулъя.

“Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох тухай”,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5.5 дахь заалт, 120 дугаар зүйлийн 120.1.1 дэх заалт, 120.2 дахь хэсэг, 121 дүгээр зүйлийн 121.1 дэх хэсэг, 121.13 дахь хэсэг, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 29.2.4 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Ерөнхий хяналтын сонсголыг агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл сэдвээр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

3.Ерөнхий хяналтын сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар Баасандоржид даалгасугай гээд л ийм тогтоолын төслийг танилцуулж байна.

“Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох тухай” Байгаль орчны хорооны тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулъя. Энд саналтай гишүүн байх байна уу, байхгүй биз дээ тээ? Асуучихсан тээ.

Наранбаатар гишүүнтэй асуулт асууя.

Н.Наранбаатар: Энэ 3 дугаар заалт дээр нь хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг даалгасугай гэхчхэн байгаа. Энэ чинь нөгөө эргээд дүнг чуулганд юм уу, Байнгын хороонд танилцуулсугай гэх үү, үгүй юү? Тийм юм байх шаардлагатай юу, үгүй юү, яах ёстой юм? Ингээд сонсгол зохион байгуулаад л дуусчих юм уу? Чуулганаар энэ чинь үр дүн юмнууд нь орохгүй юм уу?

Б.Бейсен: Чинбүрэн гишүүний микрофоныг. Чинбүрэн гишүүний микрофоныг өгье. Асуудаа.

Ж.Чинбүрэн: Байнгын хороо өөрөө Их Хурлын тогтоол гаргах саналыг Их Хуралд гаргах боломжтой юм.

Б.Бейсен: Тогтоолын төслийг баталъя. Санал хураалт.

Батжаргал гишүүн, Золжаргал гишүүн хоёрыг дэмжсэнээр протоколд тусгая. Найдалаа гишүүнийг бас дэмжсэнээр тусгая.

Санал хураалтын дүнг танилцуулъя. 78.6 хувиар дэмжигдсэн байна. Дараагийн асуудалд оръё.

Улсын Их Хурлын гишүүн Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Золжаргал, А.Ганбаатар гишүүн Байнгын хорооноос байгуулагдсан агаарын бохирдлын утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын мэдэгдлийг хангах зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллах талаар хүсэлтийг тус хороонд тус тус ирүүлсэн байгаа.

18.42 цаг

“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22 дугаар зүйлийн 3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийг үндэслэн

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооноос тогтоох нь:

Агаарын бохирдол утааны асуудлаар Ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангаж, зохион байгуулах групп бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Золжаргал, Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар нарыг нэмсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байгаа.

Энэ тогтоолын төслийг баталъя гээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

Мандухай гишүүнийг дэмжсэнээр авъя.

Тогтоолын төсөл маань 85.7 хувиар батлагдлаа.

Байж байгаарай. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдье.

Хуралдаанд оролцсон Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

18.44 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*